



РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ  
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 7/09

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Харилцаа холбооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, "Радио телевизийн үндэсний сүлжээ" Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.3.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын "Улаанбаатар хотын хэмжээнд гарч буй радио дамжуулалтын гэмтэл саатлыг засварлахаар нийтийн тээврийн хэрэгслээр явж буй ажилчдад унааны зардал олгох журам"-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллахыг Хотын шугамын радиогийн алба (Э.Төмөрчөдөр), Захиргааны удирдлагын газар (Ц.Ганзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын захирлын 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 64 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  Б.ДАГВАСҮМБЭРЭЛ



1624010017

“Радио телевизийн үндэсний сүлжээ”  
Улсын төсөвт үйлдвэрийн газрын  
захирлын 2024 оны 22 дүгээр сарын  
23-ны өдрийн 109 тушаалын хавсралт

**УЛААНБААТАР ХОТЫН ХЭМЖЭЭНД ГАРЧ БУЙ РАДИО ДАМЖУУЛАЛТЫН  
ГЭМТЭЛ СААТЛЫГ ЗАСВАРЛАХААР НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ЯВЖ  
БУЙ АЖИЛЧДАД УНААНЫ ЗАРДАЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Зорилго**

Энэхүү журмын зорилго нь өдөр тутам гарч буй радиогийн гэмтэл, саатлыг хурдан шуурхай засварлах, шинэ тавилтын хайгуул хийхэд нийтийн тээврээр ажил үүрэг гүйцэтгэж буй ажилчдад нийтийн тээврээр зорчих зардлын мөнгийг олгох, тайлагнахтай холбоотой асуудлыг зохицуулахад оршино.

**Хоёр. Нийтийн тээврээр зорчих зардлын мөнгийг олгох, ажилчид хийж  
гүйцэтгэх ажлууд**

- 2.1. Хотын шугамын радиогийн албаны ажилчид ажлын шаардлагаар нийтийн тээврээр зорчих үед олгогдох зардлыг (1 удаагийн зорчилт 500 төгрөг) тухайн өдөрт явсан бүртгэлээр тооцож, цалин дээр нэмж олгоно.
- 2.2. Улаанбаатар хотод үйлчилж буй нийтийн тээврийн хэрэгслийн үнэ тарифаар тооцно.
- 2.3. Нийтийн тээврээр зорчих зардлыг олгохдоо Хотын шугамын радиогийн албаны дарга тухайн сарын ажлын нарядыг үндэслэн, ажилчдын ажилласан өдрийн бүртгэлийг гаргаж өгнө.
- 2.4. Инженер, техникийн ажилчид дараах ажлуудыг өдөр тутам хийж гүйцэтгэсэн тохиолдолд унааны хөлс олгогдоно. Үүнд:
  - 2.4.1. Радиогийн гол ба салбар шугамын гэмтэл засварлах
  - 2.4.2. Радиогийн шугамын гадны нөлөө, технологи, хэмжилт, зураглал гаргах
  - 2.4.3. Радиогийн гол ба салбар шугамд хэмжилт хийх
  - 2.4.4. Техник тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх
  - 2.4.5. Ажлын зурган дээр хийгдэх радио шугамын тодруулга хийх
  - 2.4.6. Техникийн нөхцөлийн дагуу техник тоног төхөөрөмжид паспортжуулах

**Гурав. Нийтийн тээврээр зорчих зардал мөнгөний олголт,  
зарцуулалт, түүнд тавих хяналт, тайлагнах**

- 3.1. Хотын шугамын радиогийн албаны хэмжээнд нийтийн тээврээр зорчих инженер, техникийн ажилчдын тухайн сарын зардлыг сарын эхэнд 1 удаа (сарын эхний ажлын 5 хоногт) олгоно.
- 3.2. Олгогдсон нийтийн тээврийн зардлын зарцуулалтын тайланг тухайн сарын сүүлийн ажлын өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер нэгтгэх ба Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч заагдсан маягтын дагуу хянаж баталгаажуулна.
- 3.3. Нийтийн тээврийн зардлын тайланг Хотын шугамын радиогийн албаны менежер дараа сарын ажлын эхний 3 өдөрт багтаан санхүүд хянуулж тайлагнана.
- 3.4. Санхүү бүртгэлийн хэлтэс өмнөх сарын зарцуулалтын тайланг шалгаж хүлээн авах ба материал бүрдсэн бол дараа сарын нийтийн тээврийн зардлыг ажлын 5 хоногт олгоно.